

АГУУЛГА

хуудас

1. Төслийн талаарх мэдээлэл, товч танилцуулга	2
2. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	3-5
3. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт	6
3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	7-8
3.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө, зорилт	9-10
3.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний	11
3.4. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	12
3.5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	13-16
3.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөны	17
3.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	18-21
3.8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	22-23

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр:	Төмөр бетон эдлэлийн үйлдвэрүүд
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр:	Арга хийц-Од ХХК Улсын бүртгэлийн дугаар: 9020030317 Ригистрийн дугаар: 6542522
Хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүргийн 20-р хороо, Эрчим хүчний гудамж 292 тоот. Утас: 99039731, 99904954

“Арга хийц Од” ХХК нь Барилгын салбар эрчимтэй хөгжиж буй өнөө үед барилгын үндсэн болон туслах түүхий эд материалыг технологийн горим, дараалал, хэрэглэгдэж буй түүхий эд, материалын чанарт тавигдах стандартын шаардлагыг хангасан үйлдвэрлэлийг хэвийн дэг журамтай явуулах, улсын чанарын баталгаажуулалтын үзүүлэлтэд бүрэн тохирсон, хэрэглэгчийн хэрэгцээ хангасан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх зорилготой.

Төслийн талбай нь Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт, тус дүүргийн Засаг даргын 2021 оны 11 сарын 22-ны өдрийн А/514 тоот шийдвэрийг үндэслэн, нэгж талбарын 1681910209 дугаар бүхий 7874 м² газрыг үйлдвэрийн газрын зориулалтаар 13 жилийн хугацаатай эзэмшихээр эрх авсан байна.

Бетон зуурмагийн үйлдвэр нь 1 цагт 30м³ үйлдвэрлэх хүчин чадалтай солонгос улсад үйлдвэрлэсэн бүрэн автомат үйлдвэр байна.

Зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн байдлаас хамаарч жилд дунджаар 9000м³, сард 1000м³

орчим бетон зуурмаг үйлдвэрлэж байна. Төслийн хүрээнд нийт 25 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна.

Төмөр бетон эдлэлийн үйлдвэрийн үйлдвэрлэлийн технологийн үндсэн зарчим нь суурин стендийн арга болно. Хэвлэх цех дэх технологийн шугам нь БНХАУ болон БНСУ-д үйлдвэрлэсэн техник тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон бөгөөд жилд 6000м³ төмөр бетон эдлэл үйлдвэрлэх хүчин чадалтай.

“Арга хийц Од” ХХК нь 2020 оноос хойш тасралтгүй Төмөрбетон эдлэлийн үйлдвэрийн чиглэлээрээ дагнан ажиллаж байна. Төмөр бетон эдлэлийн үйлдвэрийн үндсэн түүхий эд болох бетон зуурмагаа өөрийн бетон зуурмагийн үйлдвэрээс шууд нийлүүлдэг.

- Үйлдвэрийн үндсэн хэсгүүд:
- Арматур бэлтгэлийн хэсэг
- Хэв хашмал бэлтгэх хэсэг
- Дулааны боловсруулалтын хэсэг
- Бэлэн бүтээгдэхүүний агуулах
- Бетон зуурмагийн узель гэсэн үндсэн 6 хэсэгээс бүрдэнэ.

Төмөрбетон эдлэлийн үйлдвэр буюу Дулааны сувгийн тэвш, таг, Зоорийн ханын гулдмай, Холбооны ба цахилгаан дамжуулах шугамын шонгийн залгаас, Холбооны угсармал худаг гэсэн нэр төрлийн жилд 6000-6300м³ бетон эдлэл үйлдвэрлэнэ.

ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Аливаа төслийн байгаль орчинд үзүүлэх болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг зөв оновчтой тогтоох нь байгальд ихээхэн хэмжээний хохирол учруулан, эвдрэл доройтолд орохоос сэргийлэн улмаар хүрээлэн буй орчныг хамгаалах чухал арга хэмжээ юм.

“Арга хийц од” ХХК-ийн “Төмөр бетон эдлэлийн үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж болох болзошгүй сөрөг хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдал, үйлдвэрийн ажлын байранд ажиглалт тандалтын зарим судалгаа хийсэн болно. Өмнөх бүлгүүдэд авч үзсэн төслийн хүчин чадал, байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг бүрээр хийсэн суурь судалгаа зэрэгт тулгуурлан төслийн үйл ажиллагааны байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг БОНХЯ-ны 2014 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А-117 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний аргачлал”-ын дагуу хийж гүйцэтгэлээ.

Дээрх үүсч буй сөрөг нөлөөллүүд нь төслийн үйл ажиллагаатай холбогдон гарч байгаа болно. Хүснэгт 1-д голлох сөрөг нөлөөллийг үйлдвэрийн үйл ажиллагаа болон байршилтай холбогдуулан голлох сөрөг нөлөөллийг схемчлэн харуулав.

2.1. Гол сөрөг нөлөөлөл

Төслийн үйл ажиллагаатай холбогдуулан байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг байгалийн хам бүрдлийн хэсгүүдтэй уялдуулан авч тодорхойлбол:

Байгаль орчинд үзүүлэх бохирдол, нөлөөллийн эх үүсвэр, шинж чанар, өргөгдлийн байдал

Хүснэгт 1

№	Бохирдол, нөлөөлөл	Нөлөөллийн эх үүсвэр (үйл ажиллагаа)	Нөлөөллийн шинж чанар, өртөгдлийн байдал
1	2	3	4
Нэг. Орчин			
1.1	Тоосжилт	Түүхий эд туслах материалыг тээвэрлэх, буулгах, зөөх болон үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас үүсэх	Үйлдвэрийн доторх агаар орчинд тархах, ажилчдын эрүүл мэндийн байдалд нөлөөлнө
1.2	Дотоод шаталтын хөдөлгүүрийн хорт хий, угаар	Тээвэрлэлтэд хэрэглэгдэх машин, механизм	Агаар орчинд тархах боловч хадгалагдах болон тархах хүрээ хязгаарлагдмал
Хоёр. Усан орчин			
2.1	Хатуу болон шингэн хог хаягдал	Шингэн хаягдал болон шатах тослох материалын хадгалалт, ашиглалтын аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдсөнөөс үүсэх Хаягдлын байгууламжийн бүрэн бус байдал, зайлуулах, тээвэрлэлтийн явцад техникийн бүрэн бус байдал, хүмүүсийн анхаарал хайхрамжгүйн улмаас асгарах,	Хур борооны усаар угаагдаж хөрс, гүний ус бохирдуулна
Гурав. Хөрс			
3.1	Эвдрэл	Бүтээн байгуулалт, барилгын ажлын үед суурь ухах хөрс эвдэгдэх, овоолгод дарагдах, дагтарших, талхлагдах	Хөрсний физик механик шинж чанарт өөрчлөлт орж болно. барилгын ажлын дараа нөхөн сэргээх боломжтой.
3.2	Бохирдол	Ахуйн хог хаягдал Шатах тослох материал болон үйлдвэрийн түүхий эд барьцалдуулагч материал, нэмэлтийг ашиглах, тээвэрлэх явцад асгах, зориулалтын бус нөхцөлд хадгалах	Бохирдлоос сэргийлэх, нөхөн сэргээх боломжтой Хэмжээ хязгаарлагдмал Хөрс бохирдсоноос хөрсний микробиологийн шинж чанарт өөрчлөлт орж болно Шавж, хорхой, байршлаа сэлгэх, хордох, үхэж үрэгдэж болно.
Дөрөв. Ургамал бүрхэвч			
4.1	Газар шорооны ажлын үед	Ургамлан бүрхэвч бүхэлдээ устгагдах, дарагдах байдлаар үгүй болно.	Хэмжээ хязгаарлагдмал Төрөл, зүйл устаж, өөрчлөгдөж болно

4.2	Талхлагдах	Хүний хөл, үйл ажиллагаанд байнга өртөж буй зөрөг зам, жим, талбай, ашиглалтын объектуудын орчин	- Биомассын хэмжээ багасна - Төрөл зүйл устаж болно - Нөхөн сэргээхэд бэрхшээлтэй болж болно.
Тав. Нийгэм эдийн засгийн орчин			
5.1	Эко бүтээгдэхүүн үйлдвэрлэл	Байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх	- Орчин үеийн чанарын шаардлага хангасан, дэвшилтэт технологи бүхий бүтээгдэхүүнээр зах зээлийн эрэлт
5.2	Шинээр ажиллагсад авна	Эдийн засгийн чадавх дээшилнэ. Ажлын байр шинээр бий болно	- Тогтмол

Төмөр бетон эдлэлийн үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчны төлөв байдал, экологи, орон нутгийн нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн үнэлгээг магадлан жагсаах аргаар хийж хүснэгт 2-д үзүүлэв.

Судалгаанаас үзэхэд тус үйлдвэрийн үйл ажиллагаа нь байгаль орчинд шууд ба шууд бус нөлөөллийн давхардсан байдлаар 22 нэр төрлийн нөлөөлөл үзүүлж болзошгүй байна. Эдгээрээс улсын хэмжээнд нийгэм, эдийн засгийн чиглэлээр үзүүлж буй эерэг нөлөөлөл 9 байгаа бөгөөд үлдэх 13 хэлбэр нь сөрөг нөлөөлөлд хамаарна. Төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийг магадлан жагсаалтад оруулан тэдгээрийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, нөлөөллийн байдал зэргийг нэгтгэн тодорхойлсноор ерөнхий дүр төрхийг харж болох юм. Мөн нөлөөллийн байдлыг дор дурдсанаар авч үзэж болохоор байна.

Хүснэгт 2. **Болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим**

Байгаль орчны үзүүлэлт	Нөлөөлөл			Хугацаа		Давталт		Эрчим		
	шууд	шууд бус	өөрөө зохицуулагдах	богино хугацааны	урт хугацааны	буцаж нөлөөлөх	бүцрлтгүй нөлөөлөх	хүчтэй	дунд зэрэг	бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсцын өөрчлөлт										
Газрын доорх усны чанарын өөрчлөлт		x			x					x
Ургамлын бүтцийн өөрчлөлт	x			x						x
Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x		x	
Геологийн тогтцын өөрчлөлт										
Зэрлэг амьтдын орон зай										
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт		x								x
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг										
Бэлчээрийн байдал										
Эрдэс түүхий эдийн нөөц										
Эрчим хүчний нөөц		x			x					x
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ	x				x					x
Урсгал усны хэрэгцээ										
Агаарын бохирдол	x				x					x
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x				x	
Хорт бодис хөрс, усаар дамжин хүнд нөлөөлөх		x			x				x	
Дуу чимээ, шуугианы нөлөө, чичиргээ	x			x					x	
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх										
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх										
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх										

Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	Судлагдаагүй									
Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх	Судлагдаагүй									
5. Нийгэмд үзүүлэх нөлөө										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх		x			x		x		x	
Үйлдвэрлэлийн салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх	x			x					x	
Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх	x			x					x	
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх		x		x						x
6. Эдийн засаг, байгаль орчин										
Татварын орлого өөрчлөгдөх	x			x					x	
Орон нутгийн орлого нэмэгдэх	x			x					x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x			x					x	
Ажлын байр нэмэгдэх	x			x						x
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x			x		x			x	
6. Бусад нөлөөлөл										
Зам харилцаа, тээврийн машин механизмын хөдөлгөөн шилжилтээс болж хөрс эвдрэх		x					x			x
Ахуйн бохир уснаас хөрс ба грунтын усыг		x			x				x	
Шатахууны алдагдлаар хөрс бохирдох		x			x				x	
Дүн	13	9	-	10	10	1	3	-	13	9


ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Төмөр бетон эдлэлийн үйлдвэрүүдийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зорилго нь:

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжиж буй нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангах, БОННУ-н дэх зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, төслийн үйл ажиллагаанаас үүсэж буй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилготой. Тиймээс тариалангийн талбайн үйл ажиллагааны явцад үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төслийн хэрэгжилтийн хүрээнд авч үзээд холбогдох зардлыг төлөвлөнө. Энэхүү төлөвлөгөөг төсөл хэрэгжүүлэгч дагаж мөрдсөнөөр байгаль орчин, нийгмийн хамгааллын үүргээ хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

БОМТ-г хэрэгжүүлэхэд төсөл хэрэгжүүлэгч дараах бодлогыг баримтална. Үүнд:

- БОМТ нь төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаа, санхүүгийн боломж нөөцтэй уялдсан байх;
- БОМТ-ний хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэгч өөрөө болон оршин суугчдын зүгээс хэрхэн хянаж, харилцан хамаарал бүхий бодит үр дүнд хүрэх;
- БОМТ-г хэрэгжүүлснээр төсөл хэрэгжүүлэгчийг хөндлөнгийн хяналт, шалгалтад тэсвэртэй болох зэрэг болно.



3.1. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 3

№	Гол болон болшошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал /төгрөг/	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Агаарын чанар	Төслийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх авто машин, механизмын техникийн хэвийн ажиллагааг болон шатах тослох материалын зохистой хэрэглээг хангах	Тээвэрлэлт үйчилгээнд хэрэглэж буй тээврийн хэрэгсэл	ш	800 000	1	800 000	техникийн үйлчилгээ хийх 5 болон 9 сард Жилд 2 удаа үүнээс гадна ЕВРО ДИЗЕЛЬ түлш ашиглаж агаарын бохирдлыг бууруулна	MNS5013520038 MNS5014:2003
		Агаарын мониторинг хийх	Төсөл хэрэгжүүлж буй гадаад орчин	ш	150000	1	50 000	Жилд 1 удаа	MNS4585:2016
		Үйлдвэрийн орчны тоосжилтыг дарах усан чийгшүүлэгчийг тогтмол хийх	Үйлдвэрийн хашаан дотор	м2	1 000	100	100 000	5-9 сар хооронд	-
2	Гадаргын ба газрын доорх усны нөөц Хөрсөн бүрхэвч	Ус ашиглах дүгнэлт гаргуулах	Төслийн хүрээнд	ш				1 жилд	Усны тухай хуулийн 12.1.4 заалт, БОНХАЖ-ын сайд, Барилга хот байгуулалтын сайдын 2015оны А-30/127тоот хамтарсан тушаалаар батлагдсан УСНЫ САН БҮХИЙ ГАЗАР, УСНЫ ЭХ ҮҮСВЭРИЙН ОНЦГОЙ БОЛОН ЭНГИЙН ХАМГААЛАЛТЫН ЭРҮҮЛ АХУЙН БҮСИЙН ДЭГЛЭМИЙН МӨРДӨХ ЖУРАМ-ын 3.9 дэх заалт
		Ус ашиглах гэрээ байгуулах	Төслийн хүрээнд	ш				1 жилд	
		Усны мониторинг	Худаг	ш	162 000	1	62 000	Жилд 1 удаа	
		Хөрсний мониторинг	Үйлдвэрийн талбай	ш	56000	1	56000	Жилд 1 удаа	MNS5850:2008
	Нийт дүн						1 078 000		

3.2. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-ийн дагуу эзэмшил газрын 10 хувиас доошгүй талбайд зохих журмын дагуу зүлэгжүүлж мод тариалах шаардлагыг үүрэгжүүлж өгсөн байдаг. Салхины хаалт хамгаалалтад хашаалж ургадаг мод тарих боломж, туршилтыг судалж нэвтрүүлэх хэрэгтэй.

Оффис, ажлын байрны орчимд цэцгийн мандал байгуулах, бусад хязгаарлагдсан талбайд мод тариалах ажлыг нөхөн сэргээлт, тохижилтын төлөвлөгөөнд тусгасан байх хэрэгтэй.

Газрын нөхөн сэргээлт гэдэг нь “эвдэрсэн газрын аж ахуйн үнэ цэнэ, бүтээмжийг нь сэргээх, тэрчлэн хүрээлэн буй орчны нөхцөлийг нийгмийн ашиг сонирхолд нийцүүлэн сайжруулахад чиглэсэн цогц арга хэмжээ” юм. Жил бүр мод тарих ажлыг зохион байгуулж, өмнө тарьсныгаа арчлах, амьдраагүй хэсэгт нөхөн тарилт хийх зэргээр уламжлалт тогтсон өдөртэй болсон байх. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Баянгол дүүргийн ЗДТГ-аас заасан газарт мод тарихаар төлөвлөсөн.

2025 онд Сонгсголонгийн уулзвараас Гурвалжингийн гүүрний уулзвар хүртлэх зам өргөтгөлийн ажилтай холбоотойгоор ногоон байгууламжийн нэгээхэн хэсэг нь тусгагдаж ухалт хийгдэж үгүй болсон. Гэвч замын ажил одоог хүртэл бүрэн дуусаагүй буюу явган хүний замын ажил хийгдээгүй байгаа учраас бид дахин ногоон байгууламжаа сэргээх боломжгүй байна. Замын ажил бүрэн дуусахаар хийхгүй бол дахин ажил болох төлөвтэй байгаа учраас бид 2026 онд зураг төслийнхөө дагуу хийхээр төлөвлөсөн байна. Гэхдээ бид ногоон байгууламжийнхаа талбайг томсгох орчныг үзэмжтэй тохижуулах зорилгоор урд талын бетонон хашаагаа буулган жижиг төмөр хашаа хийж ногоон байгууламжийн бэлтгэл ажлаа 2025 онд хангасан байгаа.

2025 оны 4 сар /өмнөх/

2025 оны 11 сар /Одоо/



2023 онд

2023 онд хийгдсэн зураг төслийн хүрээнд ажилтан албан хаагчдын эрүүл ахуй, тав тухтай ажлын байраар хангаад зогсохгүй халуун хүйтэн ус, цэвэр бохир усны шийдлийг стандарт нормын дагуу шийдээд зогсохгүй орчиндоо өнгө үзэмж нэмэхээр 300м² оффисын барилгыг 2024 онд ашиглалтанд оруулж чадсан. Гадна талбайн ногоон байгууламж болон орчны тохижилт хатуу хучилттай замын ажлыг 2025 онд хийхээр төлөвлөгөөнд тусгагдсан байсан ч нийслэлийн төв замын өргөтгөлийн ажилтай холбоотойгоор тохижилт болон ногоон байгууламжийн ажил зураг төслийн дагуу хийгдэж чадаагүй. Тийм учраас бид 2026 онд дахин төлөвлөгөөндөө тусгаж байна.

Зураг төслийн хүрээнд. /Шинэчлэгдсэн зураг төсөл/

3.2.1 ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ЗОРИЛТ

Хүснэгт 4

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжмх нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал /төг/	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
1	Төслийн талбайг тохижилтын дагуу мод бут тарьж хашаалах	Жигд/3 нас/ Сухай /3 нас/ Хайлаас /3 нас/	Хашааны гадна	Шир Шир Шир	5 5 10	15000 15000 9000	240 000	10 сард Жил бүр	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль 7.2.4
2	Орчныг цэвэр байлгах талаар хороотой хамтран ажиллах	Эзэмшил газрын ойр орчмыг хогыг цэвэрлэх	Хашааны гадна авто зам, замын хөвөө	М ²	395,5	4300	1 700 650	9 сард	
	Нийт дүн						1 940 650		

Жил бүр мод зүлэг тарих ажлыг зохион байгуулж, өмнө тарьсныгаа арчлах, амьдраагүй хэсэгт нөхөн тарилт хийх зэргээр уламжлалт тогтсон өдөртэй болж арчилгааг хуваарийн дагуу гүйцэтгэнэ

3.3. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн талбай болон түүний орчмын нутагт нь түүх соёлын дурсгалд тооцож болохуйц газар болон археологийн болон палеонтологийн олдвор одоогоор тохиолдоогүй.

Цаашид үйл ажиллагааны явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрсэн үед “Монгол Улсын Үндсэн хууль”-ийн I бүлгийн 7-р зүйлд “Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна” гэж заасны дагуу түүх, соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулахтай холбоотой үүрэг хариуцлагаа мөрдөж ажиллах нь зүйтэй.

Соёлын ба үнэт өв зүйлсийг илрүүлж, тэр нь үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд эрсдэхээр байвал орон нутгийн засаг даргаас энэ үйл ажиллагааг даруй зогсоохыг шаардах, бололцоотой бол эдгээр газруудыг аль болох зохистойгоор хамгаалахыг хуульд заасан байдаг. Боловсрол, Соёл, ШУ-ны ямны тусгай зөвшөөрөлгүйгээр зөөж шилжүүлэх боломжгүй соёлын ба үнэт дурсгалын өвийг малтах, зөөх, эвдэхийг хуулиар хориглосон.

3.4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Осол эрсдлээс хамгаалах ажлын ихэнх нь төслийн үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол, цаашлаад зэрлэг ан амьтдын ослоос урьдчилсан сэргийлэх ажилд холбогдох зардал нь төслийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой юм.

Хүснэгт 5

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ	нийт зардал /Т/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах хууль, журам стандарт
1	Гал түймэр	1. Ажлын балбайд гал түймрээс сэргийлэх боломжтой бүх арга хэмжээг авах 2. Дараах эрсдэл бууруулах арга хэмжээг авах. - Нийт ажилчдыг гал унтраах сургалтанд хамруулах - Аюулын гарцын байршилыг заасан самбар байрлуулах, галын дохиолол, гал унтраагуур тэмдэг тавьсан байх хэрэгтэй. 3. Гал гарсан тохиолдолд: - Галаас яаралтай гарах - Гал түймрийн үед барилга байгууламж бүрд тохирох зааварыг ашиглах.	Төслийн бүх байршилд					Галын аюулгүй байдлын тухай хууль /шинэчилсэн найруулга/ 3-р бүлэг Гамшигаас хамгаалах тухай хууль, 5-р бүлэг
2	Хүний эрүүл мэнд муудах	Хүний эрүүл мэнд муудахад харьяа дүүрэг, хорооны эрүүл мэндийн нэгдсэн төвд хүргэх арга хэмжээг авна.	Төслийн бүх байршилд	-	-	-		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, 3, 4 дүгээр бүлэг
3	Цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол	Урьдчилан сэргийлэх мэдээ болон дориолол холбооны найдвартай байдлуудыг байнга хангах	Төслийн бүх байршилд	-	-	-		

3.5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

"Арга хийц од" ХХК-ний төмөр бетон эдлэлийн үйлдвэр төслийн үйл явцад болон үйл ажиллагааны үед гарч болох хог хаягдлын эх үүсвэрийг Монгол улс болон олон улсын хууль тогтоомж, стандарт шаардлагын дагуу хянах, бууруулахад чиглэгдэх юм.


Аливаа төслийн үйл ажиллагаанаас үүдэн хог хаягдал үүсгэх нь зайлшгүй бөгөөд холбогдох хууль, журмын дагуу хог хаягдлын менежментийг системийн арга хандлагыг тодорхойлсон болно.

Төлөвлөгөөнд төслийн холбогдох стандартуудыг тогтоох, нөлөөлөл бууруулах арга хэмжээний хяналт шинжилгээ ба аудитын хөтөлбөр зэрэг төслийн хог хаягдлын менежментийн удирдлагуудыг тогтоож өгсөн.

ЗОРИЛГО

Энэхүү менежментийн төлөвлөгөөний зорилгууд нь:

- Хог хаягдлын менежментийн талаарх дотоодын болон олон улсын хууль, журам, стандартуудыг тодорхойлох;
- Барилгын ажлын үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын нөлөөллийн болзошгүй эх үүсвэрүүдийг тодорхойлох;
- Хог хаягдлын менежментийн үйл ажиллагааны журмуудыг тодорхойлох;
- Үүрэг, хариуцлагуудыг тодорхойлох;
- Хяналт шинжилгээ/аудит болон тайлагнах журмуудыг тодорхойлох;
- Ажилчдад зориулсан сургалт зэрэг багтана.



ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ЗАРДАЛ

Хүснэгт 6

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөлийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах хууль, журам стандарт
Ахуйн, Үйлдвэрийн	Тусгайлан бэлтгэсэн хогийн саванд хадгалах, хогын цэгт хаях	Төслийн тайлбай	тн	3954.55	430	1 700 000	1 сард 2 удаа	Хог хаягдлын тухай хууль, хаягдлыг ангилан ялгаж хаях журам
Аюултай	х	х	х	х	х	х	х	х
						1 700 000		

3.6. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ, ЗАРДАЛ

Хүснэгт 7

Авч хэрэгжүүлэх арга хэмжээ		Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			сар	сар	сар		
БОМТ-нд тусгагдсан ажлын дэлгэрэнгүй төсөвийг гаргаж дотооддоо батлах		-	3	-	-	Л.Ганзориг	
Ногоон байгууламж цэцэрлэгжүүлэлтийн ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран хийх		300 000	5	6	-	Л.Ганзориг	
Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилсан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх		200 000	3	-	-	Л.Ганзориг	
Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, ангилах, Хог хаягдлын хор хөнөөлийн таниулах лекц явуулах		300 000	3	-	-	Л.Ганзориг	
НИЙТ ДҮН		800 000					

3.7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Төслийн үйл ажиллагаанаас үүдэн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх, бууруулах, арилгах зорилгоор байгаль орчны төлөв байдал, шинээр үүсэн бий болсон нөхцөл байдалд ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг “орчны хяналт шинжилгээний хөтөлбөр” гэнэ.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр нь “Төмөр бетон эдлэлийн үйлдвэр” төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд гарч байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлох, болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилготой.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт дараах зүйлсийг тусгасан байх болно. Үүнд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн тус бүрт үзүүлэх нөлөөлөл;
- Хяналт-шинжилгээ явуулах зайлшгүй шаардлагатай үзүүлэлтүүд;
- Хяналт-шинжилгээ явуулах төрөл, хэлбэр;
- Хяналт-шинжилгээ хийх, сорьц авах цэгийн байршил;
- Хяналт-шинжилгээ явуулах хугацаа, давтамж;
- Хяналт-шинжилгээ явуулах арга, аргачлал;
- Хяналт-шинжилгээ явуулахад шаардлагатай техник, тоног төхөөрөмж;
- Хяналт-шинжилгээний үр дүнг нэгтгэх, тайлагнах арга, хэлбэр зэрэг болно.

Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь төслийг хэрэгжүүлэх явцад үүссэн сөрөг нөлөөлөл, түүнийг бууруулах үйл ажиллагаа ямар үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний үндэслэлийг боловсруулах, орон нутгийн захиргаа болон нутгийн оршин суугчдад бодит мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой.

Ийнхүү орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг боловсруулахдаа 2011 оны 2-р сарын 16-ны өдрийн БОАЖЯ-ны сайдын №А-36 тоот тушаал "Журам шинэчлэн батлах тухай /Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр, тайлан боловсруулах, хянан хүлээн авах, батлах журам/-ыг удирдлага болгон ашиглав.

НЭГ. АГААРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

1.1. Хяналт шинжилгээ явуулах зайлшгүй үзүүлэлтүүд:

> Хүснэгтээс харна уу.

1.2. Хяналт шинжилгээ явуулах төрөл, хэлбэр:

> Сорьцавах

> Хэмжилт хийх

1.3. Байршил

> Хүснэгтээс харна уу.

1.4. Хэрэглэгдэх багаж:

> Сорьц авах тоос шахуурга, бага хурдтай дээжлэгч иж бүрдэл, хийн сорьц цуглуулах уут эсвэл цилиндр)

> Шууд хэмжлийн багажаар

1.5. Хийх ажлын дараалал:

> Тогтоосон хугацаанд сонгосон цэгт багажийг байрлуулна.

> Орчны бичиглэл хийнэ. Цаг агаарын төлөв байдлын талаар орчны бичиглэл хийнэ.

> Хэмжилт хийх үеийн агаар, хөрсний температур, салхины хурд, чиглэл, агаарын харьцангуй чийг зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлж тэмдэглэл хөтөлнө.

> Зориулалтын автомат багажийн тусламжтайгаар хэмжилтийг гүйцэтгэнэ.

1.6. Хяналт шинжилгээ явуулах хугацаа, давтамж:

• Хүснэгтээс харна уу.

1.7. Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал:

> MNS 5003:2000. Чимээ шуугианы-Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй. Чимээ шуугианыг хэмжих

- > MNS 1EC 17-5-1-21-92. Автотээврийн хэрэгслийн дуу чимээ, дуу чимээний хүлцэх түвшин, хэмжих арга
 - > MNS 5803:2007. **Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй Ажлын байрны агаар дахь хар тугалганы агууламж, ажлын байранд тавигдах шаардлага**
 - > MNS 3384:1982 Агаар мандал. Сорьц авахад тавих ерөнхий шаардлага
 - > MNS 5365:2004 Агаарын чанарын нийтлэг асуудал. Нарийн ширхэгтэй тоосыг тодорхойлох арга
 - > MNS 4990:2015 **Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд Хөдөлмөрийн эрүүл ахуй. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага.**
 - > Бусад хамаарах аргачлал
- 1.8. Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ:
- > Эрүүл ахуйн хяналтын улсын ерөнхий байцаагчийн тушаалаар батлагдсан "Хот суурингийн агаар дахь бохирдуулах бодисын агууламжийн зөвшөөрөгдөх дээд төвшин"
 - > MNS 5803:2007. **Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй Ажлын байрны агаар дахь хар тугалганы агууламж, ажлын байранд тавигдах шаардлага**
 - > MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага
 - > MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага
 - > MNS 5002:2000. Чимээ шуугиан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр. Чимээ шуугианы хэм хэмжээ болон аюулгүй байдлын ерөнхий шаардлага
 - > MNS 4990:2000. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага

ХОЁР. УСНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

- 2.1. Хяналт-шинжилгээ явуулах үзүүлэлт
- ❖ Хүснэгтээс харна уу.
- 2.2. Хяналт-шинжилгээний төрөл хэлбэр
- ❖ Сорьц авч шинжилгээ хийлгэх
- 2.3. Байршил
- > Хүснэгтээс харна:
- 2.4. Хэрэглэгдэх багаж төхөөрөмж
- > Дээжлэгч болон цэвэрхэн усны шил, мв
 - > Бактериологийн дээжийг ариутгасан зориулалтын саванд авна
- 2.5. Хийх ажлын дараалал
- > Усны дээж авах саваа бэлтгэнэ, сайтар цэвэрлэсэн байна.
 - > Дээж авах гэж буй усаар сав болон бөглөөг 2-3 удаа зайлна.
 - > Дээж авалт (дээж тус бүр хаягтай байна).
 - > Итгэмжлэгдсэн лабораторид хүргүүлэн задлан шинжилгээ хийлгэнэ.
- 2.6. Хяналт-шинжилгээ явуулах хугацаа график
- ❖ Хүснэгтээс харна уу.
- 2.7. Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал:
- > MNS 150 10523:2001. *Байгаль орчин. Усны чанар. pH-г тодорхойлох*
 - > MNS 150 7150-1:2006. Усны чанар. Аммонийн агууламжийг тодорхойлох. 1-р хэсэг. Хялбар ажиллагаатай спектрометрийн арга
 - > MNS 4423:1997. *Ундны ус. Хуурай үлдэгдэл тодорхойлох арга*
 - > MNS 150 6060:2001. Байгаль орчин. Усны чанар. Химийн хэрэгцээт хүчилтөрөгчийг тодорхойлох.
 - > MNS 150 5815:2001. *Байгаль орчин. Усны чанар. Биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийг 5 өдрийн дараа тодорхойлох. Шингэлэх ба ургуулах арга*
 - > MNS 150 11083:2001. *Байгаль орчин. Усны чанар- Хром (VI) тодорхойлох-1,5- дифенилкарбазид ашигласан спектрометрийн арга.*

- > MNS 150 11885:2011. Усны чанар. Сонгосон элементүүдийн индукцийн холбоотой плазм оптикийн цацаргалтын спектрометрийн аргаар тодорхойлох
- > Бусад хамаарах аргачлал

2.8. Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- > MNS 4586:98 Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага,
- > MNS 6148:2010 Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- > MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюул байдлын үнэлгээ
- > MNS 4943:2015 "Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус. Ерөнхий шаардлага
- > Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал ус. Ерөнхий шаардлага МИ5 6561:2015

ГУРАВ. ХӨРСНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ

3.1. Хяналт - шинжилгээ явуулах үзүүлэлт:

- > Хүснэгтээс харна уу.

3.2. Хяналт-шинжилгээний төрөл хэлбэр

- > Сорьц авч шинжилгээ хийлгэх

3.3. Байршил

- > Хүснэгтээс харна уу

3.4. Хийх ажлын дараалал

- > Дээж авахаар сонгосон талбайд (0-20) см-ийн гүнээс тус бүр (300-500) г хөрсийг хүрз, хусуур, өрмийн багажийн аль нэгийг хэрэглэн дээжийг авна.
- > Үйлдвэр үйлчилгээний байгууллагуудын орчмын хөрснөөс шинжилгээнд дээж авах гүний хэмжээ (0-15;0-25) см байна.
- > Үйлдвэр, ахуйн гаралтай хог хаягдал, бохир ус, шим бохирдол, бордоо химийн хорт болон цацраг идэвхт изотопоор бохирдсон талбайн хөрснөөс дээж авах гүний хэмжээ (0-25; 0-50) см 1,0 м байна.
- > Орчин, хөрсний гадарга, хөрсний зүсэлтийн фото зураг авна.
- > Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэл хийнэ
- > Дээж авалт (дээж тус бүр гүн, өнгө, ... солбицол бичсэн хаягтай байна)
- > Итгэмжлэгдсэн лабораторид хүргүүлэн задлан шинжилгээ хийлгэнэ.

2.5. Хяналт-шинжилгээ явуулах хугацаа, график

- > Хүснэгтээс харна уу.

2.6. Хэрэглэгдэх багаж төхөөрөмж

- > Зүсэлт хийх хүрз
- > Хөрс дээжлэгч уут, сав
- > Фото аппарат
- > Самбар, маркер

3.7. Аргачлал

- > MNS 3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл
- > MNS 3310-1991 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох
- > **MNS 3298-1991 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд**
- > MNS 2305-94 Хөрс. Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам

1.8. Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- > MNS 5850 : 2019, Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ",

- > MNS 3297: 1991 Хөрс. "Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ",
- > MNS 5850:2019. Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- > MNS 5916:2008. Байгаль орчин. Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт , хадгалалт

Эрүүл ахуйн хяналт-шинжилгээ.

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд зааснаар:

- "хөдөлмөрийн аюулгүй байдал" гэж хөдөлмөрлөх явцад хүний эрүүл мэнд, хөдөлмөрлөх чадварт үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлийн нөлөөллийн түвшин нь эрүүл ахуйн зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрээгүй байхыг
- "хөдөлмөрийн эрүүл ахуй" гэж хөдөлмөрлөх явцад хими, физик, биологийн хүчин зүйлээс шалтгаалан хүний бие махбодь, мэдрэл сэтгэхүйд өөрчлөлт орж өвчлөх, хөдөлмөрийн чадвараа түр болон бүрэн алдахаас урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үйл ажиллагааг
- "хөдөлмөрийн нөхцөл" гэж хөдөлмөрлөх явцад хүний ажиллах чадвар, эрүүл мэндэд дагнасан буюу хамссан байдлаар нөлөөлөх ажлын байрны болон үйлдвэрлэлийн орчныг тус тус ойлгох бөгөөд нисэх буудлын ажлын байрны шаардлагыг баталж хэрэгжүүлэн ажиллана. Үүнд тавих хяналт мониторинг нь дараах чиглэлийг хамарна. Үүнд:
 - Ажлын байр болон агуулах доторх агаар солилцоо, дулааны хэвийн байдал
 - Ажлын байр болон агуулах доторх гэрэлтүүлэг,
 - Ажлын байр болон агуулах доторх хог хаягдлын цэгүүдийн байршил
- Ажлын байр болон агуулах доторх зөв, боловсон үйлчилгээний дүрэм журмын танилцуулга, тэмдэгжүүлэлт

Ажлын байрны болон агуулахын агаарын орчинд агаарын хэм, хөдөлгөөний хурд, чийгшил, дулааны тархалтын үзүүлэлт тус тус хамаарна. Ажлын байрны температур нь хүйтний улиралд 10°C-ээс их, дулааны улиралд 10°C-ээс бага байна. Хэмжилтийг шалнаас дээш суугаа ажлын үед 1м, зогсоо ажлын үед 1.5м өндөрт хэмжинэ.

Аргачлал, стандартаар зөвшөөрөгдөх хэмжээ:

- MNS 4990:2000 - Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага
- MNS 4967:2000 - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Нэр томьёо, тодорхойлолт
- MNS 4968:2000 - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
- MNS 4969:2000 - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуйн сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм
- MNS 5080:2001 - Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй.

Хөдөлмөрийн нөхцөл, түүний ангилал, хүчин зүйл, хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ

- MNS 5105:2001 - Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага
- MNS 5106:2001 - Хөдөлмөрийн аюулгүй байдал, үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Мэдрэл сэтгэхүйн ачааллыг үнэлэх үзүүлэлтийн норм, тодорхойлох арга
- MNS 1E0-05H 1:2003 - Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн удирдлагын тогтолцооны талаарх удирдамж

МЫ5 В5 5906 : 2018, Барилга доторх хог хаягдлын менежмент - Ашиглалтын дүрэм

3.8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8

№	БОМТ,БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	БГД-ийн 20-р хорооны ИХТөлөөлөгч нар Арга хийц -Од ХХК-н удирдлагууд	Цаасан тайлан	Төслийн БОННУ-ний дагуу хийсэн ажлуудыг танилцуулах	11 сард	1 000 000	БОМ Л.Ганзориг	Арга хийц -Од ХХК оффис
					1 000 000		

Арга хийц-Од ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд өвлийн улиралд туул голын мөсөөр тээврийн хэрэгсэл зорчиж голын мөсийг ихээр бохирдуулдаг. Үүнээс сэргийлэн Туул голын сав газрын захиргаатай хамтран хоёр цэгт тээврийн хэрэгсэл голруу нэвтрэх боломжийг хязгаарлаж хаалт хашилт хориг тавьж ажиллаж байгаа. Мөн өөрийн эзэмшлийн ноноон байгууламж болон ойр орчмын зам талбайн хог хаягдалын байнга цэвэрлэж хэвшсэн билээ.



4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт 9

Менежментийн төлөвлөгөө	Зардлын хэмжээ, мян.төг
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	1,000.0
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1,940.0
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	-
Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,700.0
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, зардал	-
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,025.42
Тухайн жилийн БОМТ-ийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	1,000.0
Нийт	6,665.42

Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих модны газрын байршил,
Баянгол цэцэрлэгт хүрээлэн

